

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

№ 25/02

Г “Хорин хоёр дугаар бааз” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан т
хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1 дахь заалтууд, компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.2.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих” журмыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлыг 2025.04.30-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, 39-р хороо, Цагдаагийн академийн өргөн чөлөө өөрийн байрны 101 тоотод хуралдуулахаар тогтоосугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэхээр баталсугай:
 1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал Т.Зоригтбаатар танилцуулах.
 2. Компанийн 2024 оны санхүүгийн тайланг ерөнхий нягтлан М.Нэргүй танилцуулах.
 3. Компанийн санхүүгийн тайланд хийсэн Аудитын дүгнэлт.
 4. Ногдол ашиг хувиарлах тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах.
 5. Бусад.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04-р сарын 15-ны өдрөөр тасалбар болгосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай зарыг 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр дахин мэдээлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерийн компанид хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.
5. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг хурал зохион байгуулах комиссын дарга /З.ТУУЛ/-д гаргаж өгөхийг компанийн санхүүд даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь хавсралт 1-д заасан бичиг баримтыг БДК-иудаас авч танилцах эрхтэй болохыг дурдсугай.
7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах “саналын хуудас”-ын агуулгыг хавсралт 2-г зааснаар баталсугай.
8. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 14:00 цагаар тасалбар болгосугай.
9. Тогтоолын хэрэгжилтийг хангах, ажлыг зохион байгуулах үүрэг бүхий хурал зохион байгуулах бөгөөд тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- Б.Мөнгэрэл дарга
- Т.Халиун гишүүн

10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
11. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “22-р Бааз” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг хавсралт 3-д заасан маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /З.Туул/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ГҮНДЭГМАА

Санхүүгийн зохицуулах
хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-
ний өдрийн 377 дугаар тогтоолоор
баталсан
“Хувьцаат компанийн хувьцаа
эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын
нэгдүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“22-р Бааз” ХК
Хаяг:	БЗД 39-р хороо
Хурал хуралдах өдөр, цаг:	2025.04.30, 14:00
	УБ хот БЗД 39-р хороо Цагдаагийн академийн өргөн чөлөө, өөрийн байрны 101 тоот танхим
Хурлын төрөл:	Элжит
	Элжит бус
	ТУЗ
Хурал зарлагч:	ТУЗ-ын хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн санал, шаардлага гаргасан /нэр/ Саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан /нэр/
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2025.03.21
Олон нийтэд зарлах огноо:	2025.03.26 2025.04.10
Бүртгэлийн өдөр:	2025.04.15
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2025.03.31
Хүргүүлсэн огноо:	2025.03.24
Хурлын даргын нэр:	Л.Гүндэгмаа
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Дарга: М.Мөөнөнцагаан Гишүүн: М.Нэргүй
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	
Баримт бичгийн хуудасны тоо:	 1 ширхэг 7 хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

..... /З.ТУУЛ/

2025 оны 3 дугаар сарын 21-ний өдөр

**“ХОРИН ХОЁР ДУГААР БААЗ” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ**

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 39 дугаар хороо, Цагдаагийн академийн өргөн чөлөө, өөрийн байрны 101 тоотод хуралдана.

- | | |
|---|-------|
| 1. Хурлын дарга нээж үг хэлэх | 14:00 |
| 2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал Т.Зоригтбаатар танилцуулах. | 14:10 |
| 3. Компанийн 2024 оны санхүүгийн тайланг ерөнхий нягтлан М.Нэргүй танилцуулах. | 14:20 |
| 4. Компанийн санхүүгийн тайланд хийсэн Аудитын дүгнэлт. | 14:30 |
| 5. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах. | 14:40 |
| 6. Бусад. | 14:50 |
| 7. Хуралыг хааж үг хэлэх: ТУЗ-ийн дарга Л.Гүндэгмаа | 15:00 |

Хувьцаа эзэмшигчдийн хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өөрийн үйлчлүүлдэг БДК дээр ажлын өдрүүдэд (Даваа-Баасан) 9:00 цагаас 16:00 цаг хүртэл авах боломжтой.

Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдтэй холбоо барих, мэдээлэл авах утас: 3.Туул 88101625

Е-мэйл хаяг: 22r.baaz@gmail.com

**“22-Р БААЗ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРОЛЦОХ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧИГ**

“22-р Бааз” ХК-ийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах болсонтой холбогдуулан тус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд дараах бичиг баримтыг танилцуулна.

- Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан.
- Компанийн 2024 оны санхүүгийн тайлан.
- Компанийн санхүүгийн тайланд хийсэн Аудитын дүгнэлт.
- Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэр.
- Компанийн 2024 оны ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ын тогтоол болон хавсралтууд.
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг.
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалд санал авах хуудасны загвар.
- Бусад.

**“ХОРИН ХОЁР ДУГААР БААЗ” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

“Хорин хоёр дугаар бааз” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 39 дугаар хороо, Цагдаагийн академийн өргөн чөлөө, өөрийн байранд 101 тоотод хуралдана.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал Т.Зоригтбаатар танилцуулах.
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайланг ерөнхий нягтлан М.Нэргүй танилцуулах.
3. Компанийн санхүүгийн тайланд хийсэн Аудитын дүгнэлт.
4. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах.
5. Бусад.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өөрийн үйлчлүүлдэг БДК дээр ажлын өдрүүдэд (Даваа-Баасан) 9:00 цагаас 16:00 цаг хүртэл авах боломжтой.

Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдтэй холбоо барих, мэдээлэл авах утас:
З.Туул 88101625

Е-мэйл хаяг: 22г.baaz@gmail.com

**“22 Р БААЗ” ХК НИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

“Хорин хоёр дугаар бааз” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны хурал 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 39 дугаар хороо, өөрийн байранд 101 тоотод болно.

Хувьцаа эзэмшигч /эсхүл төлөөлөх этгээд / овогтой Төлөөлж байгаа бол хэнийг, эсхүл ямар хуулийн этгээдийг төлөөлж буй хэн болох тухай тайлбар

Регистрийн дугаар

Гэрийн хаяг

Эзэмшиж буй хувьцааны тоо

Кумулятив аргаар өгөх саналын тоо

Бүртгэсэн: /үнэт цаасны компанийн нэр /

Брокерын овог нэр

Д/д	Санал өгөх асуудлын агуулга	Зөвшөөрсөн саналын тоо	Татгалзсан саналын тоо	Түтгэлзсэн саналын тоо
1.	Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулга			
2.	Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн танилцуулга			
3.	Санхүүгийн тайланд хийсэн аудитийн дүгнэлт.			
4.	Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах.			
5.	Бусад.			

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг..... /

Санал авахыг хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон:

Тооллогын комиссын дарга / Б.Мөнгэрэл /

Гишүүн / Г.Халиун /

Шалгаж хүлээн авсан БДК-ийн ажилтан /

Санал авах хуудсыг ашиглах санамж:

- Санал авах хуудсыг засварласан балласан тохиолдолд санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.

- Хэрэв та хуралд өөрийн биеэр оролцохгүй тохиолдолд саналын хуудсаа өөрийн харъяа брокер дилерийн компани дээрээ бөглөж үлдээнэ .

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаар 88101625 тоот утсаар лавлаж болно.